

Хэсэг 13

Монголд социалист болон социализмын дараах ижилсэл төлөвшсөн байдал

Дэвид Снийт

Редакторын тайлбар: Өрнөдийн нэр хүндтэй Монгол судлаач, доктор Снийт илтгэлдээ Монголын угсаатан, үндэстний бүтэц болон ХХ зууны Монголчуудын дунд дахь бүлгийн ижилслийг энэ цаг үетэй холбон авч үзсэн байна. Тэрээр угсаатан, нутаг, төрөл садан болон үндэстний ижилсэл гэсэн ойлголтууд нь харьцангуй уян хатан байдлаар тодорхойлогдон томъёологдсон байдгийг онцлохын сацуу Монголын нийгмийн зохион байгуулалтын хэлбэрүүд болон бүлгийн ижилсэл нь хэрхэн идэвхтэйгээр бүрэлдсэн хийгээд цаг хугацааны явцад нийгмийн өөр зорилго, улс төрийн өөр дэглэмийн үед хэрхэн өөрчлөгдөж байсныг тодорхой гаргажээ. Энэ нь түүхийн удаан хугацааны туршид үргэлжлэх үйл явц бөгөөд социалист нийгмийн үед ч мөн үндэстний болон нутгийн бүлгийн нэгдэл холбооны нэр томъёо болон ижилсэл цогцлоон бүрдүүлэх үйл явц үргэлжилж байсан байна. Түүгээр зогсохгүй энэхүү үйл явц нь социалист нийгэм нуран унасны дараагаас өнөөдрийг хүртэл Монголд үргэлжилсээр байгаа бөгөөд улс төрчид өөр өөр газруудад идэвхтэй, нөлөө бүхий дэмжигчидтэй болох зорилгоор төрөл бүрийн ижилсэл болон нийгэмлэгийн хэлбэрүүдийг хөдөлгөн ашигладаг байна. Энэхүү үйл явцын дунд улс төрийн бүлгүүд, угсаатны бүлгүүд хооронд эрс ялгаагүй, давхцан хэлхэлдсэн сүлжээ, бүлгийн ижилсэл бүрэлдсэн байна. Зөвхөн тухайн нутагт хамаарах ижилслээс эхлэн нийт улсыг бүхэлд нь хамрах уян хатан байдлаар цогцлоогдсон Монголын бүлгийн ижилсэл нь өнөөдрийн Монгол Улс дахь бүлгүүдийн хөдөлгөөн хөгжил, нууцлагдмал далд байдал, цогц байдал болон бүлгүүдийн нийгмийн хуваагдлын дутмаг байдлыг ойлгох гол түлхүүр юм.

Доктор Снийтийн бүтээл нь түүхэн мэдээлэлд тулгуурласан, онолын хувьд зөв оновчтой, ач холбогдол бүхий илтгэл болжээ.

Зөвлөлтийн албан ёсны түүхийн сурвалжууд орчин цагийн үндэстний болон угсаатны бүлгүүдийг өнгөрсөн үетэй холбон үздэг байсны дагуу “монголчууд” эсвэл “халхууд”-ын талаар мөнхүү цаг үетэй уялдуулан тайлбарлаж байлаа [Гонгор 1978]. Гэвч сүүлийн үеийн зарим эрдэмтэд энэхүү байдлыг өөр өнцгөөс харан тайлбарлахыг оролдох болсон юм. [Atwood 1994, Bulag 1998, Kaplonski 1998, Мөнх-Эрдэнэ 2006, Elver-skog 2006-ийг үзнэ үү]

Монгол нь XX зуунд үндсэрхэх үзлийн Зөвлөлтийн хувилбарын нөлөөнд автсан юм. Монголын төр нь нэг үндэстэн улсыг цогцлоохын зэрэгцээ Зөвлөлтийн загварын дагуу уламжлал гэх ойлголтын дор өнгөрснийг ч мөн тодруулан бүтээсний сацуу үндэстэн доторх угсаатны дэд бүлгүүд болох аймаг, ястанг тодорхойлох угсаатны зүйн асуудлыг гаргаж ирсэн. Зөвлөлт маягийн социалист систем нуран унаж, олон намын тогтолцоот парламентын засаглал хөгжиж эхэлснээр уламжлал болон бүлгийн ижилслийн тухай ойлголт нь улс төрчдөд олон нийтийн дэмжлэгийг авахын тулд иргэдийг хөдөлгөх гол хөшүүрэг болсон байна. “Нутаг” хэмээх ойлголт нь тухайлан онцгой ач холбогдолтой ба энэ нь нийгмийн сүлжээ харилцааны ач холбогдлыг тодорхой хэмжээнд өөртөө тусгасан байдаг.

Лаклау “ард түмнийг цогцлоон бүрдүүлнэ гэдэг нь улс төрийн үйл ажиллагааны шилдэг жишээ юм” хэмээн тэмдэглэсэн байна [2005: 154]. Хэдийгээр эдгээр “тодорхойгүй “ард түмэн” өөрсдийн онцлог шинжийг бүрдүүлэн тодрон гарч ирэх нь янз бүрийн хэлбэрээр илэрч болох” ч [Сапован 1981: 294] үндсэрхэх болон популист үзлийн аль аль нь дээрх цогцлоон бүрдүүлэлтийг шаарддаг байна. Үндсэрхэх үзэл хийгээд угсаатан нь ихэнхдээ нэгэн зэрэг бүрэлддэг ба “угсаатан гэдэг нь төр улс бүрэлдэх үйл явцад тухайн төрийн онцлог шинжүүдийг бүрэлдүүлэх үйл явцын нэг хэсэг үр нөлөө” гэж Алонсо [1994: 391] тэмдэглэсэн байдаг.

Хорьдугаар зууны эхэнд Зөвлөлтийн Коминтерн “хувьсгалт” үндэстэн болон угсаатны бүлгийг илэрхийлэх шинэ нэр томъёо гаргаж ирсэн юм. Тухайн үед Монголын үндсэрхэх үзлийн үгсийн санг бүтээлцсэн гол зүтгэлтнүүдийн нэг нь Санкт-Петербургийн Их сургуульд суралцсан, Буриадын үндсэрхэг үзэлт, угсаатны зүйч Цэвээн Жамсрано юм. Тэрээр угсаатны бүлгүүдийн түүхэн үе шатуудын талаарх Зөвлөлтийн онолын гол элементүүдийг Монгол нэр томъёонд хөрвүүлэн буулгасан байдаг. Тухайлбал, орос хэлний “народность” (угсаатны бүлэг/яс үндэс) гэдэг үгийг Монгол хэлний ястан гэсэн үгтэй дүйцүүлэн орчуулсан байна.

Овог аймгийн нэгэн адил угсаатны бүлэг гэх үзэл ойлголт нь төрөл садангийн холбоо хэмээх ойлголтод суурилсан байдаг [Hobsbawm 1990: 63] бол Алонсо эсрэгээр нь “угсаатны бүлгүүд нь тодорхой, нэг ижил, нэгдмэл соёлтой, удмын сангийн хувьд нэг гаралтай байдаг гэдэг нь эндүү ойлголт” гэж үзсэн байдаг. Үнэхээр ч ястан гэх угсаатны бүлгүүд нь тухайн нутгаас гаралгүй ч түүхэн цаг хугацааны явцад удирдагчид улс төрийн хувьд тодорхойлж бүрдүүлсэн нэгдлүүд юм. Тухайлбал, Ховд аймгийн өмнөд хэсгээр нутаглах Захчин нь анхандаа хил хамгаалах үүрэг бүхий хэд хэдэн нэгжүүдээс бүрдсэн Зүүнгарын засаг захиргааны нэгжийг нэрийдэж байсан нэр юм. Уг нэгжийн засаг ноён нь Чин улсад бууж өгч дагаар орсны дараа тэднийг засаг захиргааны нэгж болох хошуу болгон Ховдод суугаа Манжийн амбанд туслах үүрэг оноосон байна [Atwood 2004: 617]. Тэд засаг захиргааны хувьд онцгой хэвээрээ байсаар Зөвлөлтийн үед тэдгээр иргэдийг захчин ястан гэх болсон байна. Монгол Улсын шинээр сонгогдсон Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж захчин ястан юм. Социалист систем нуран унасны дараа үндэстэн, ястны цөөнхөөс төрөн гарч байгаа улс төрчдийн сонгуульд үзүүлж буй амжилт болон төрийн өндөр албан тушаалд эзлэх байр суурь зэрэг нь Монголын улс төрд Халх төвт үзэл

давамгайлдаг гэх Булагийн дэвшүүлсэн үзлийг үгүйсгэж байгаа юм. Мөн тэдгээр үндэстний цөөнхийн төлөөлөл болсон улс төрчид чамгүй олон халх сонгогчдын саналыг авч чадсан байдаг. Түүнчлэн Монголд аливаа яс үндэс, шашин шүтлэгт тулгуурласан улс төрийн нам, эвсэл ч байдаггүй. Угсаатны бүлгүүдийг улс төрийн намын бус соёлын зорилгоор зохион байгуулалтанд оруулж хөдөлгөх нь үр дүн багатай байдаг. Өдгөө ястан буюу угсаатны бүлгүүдийг хөдөлгөхийг хичээж буй хөдөлгөөнүүд олон байгаа нь тэд сонгуульд чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг баталж байгаа юм.

Улс төрийн хувьд үндэстний дотоод дахь бүлгийн ижилслийн хамгийн тод хэлбэр нь угсаатан гэхээсээ илүү нутаг юм. Нутаг дэвсгэр нь засаг захиргааны хувьд дэд шатлал бүхий нэрлэсэн нэгжүүдэд хуваагддаг тул нутаг гэдэг нь ихэнх тохиолдолд засаг захиргааны нэгжүүдийн хүрээнд ойлгогддог. Энэ нь саяхан гарч ирсэн зүйл биш бөгөөд бүсийн улс төрийн ижилсэл нь өнгөрсөн үед ч чухал ач холбогдолтой байсан. Төрсөн нутаг дахь үндэс гарвалаа чухалчлах нь Монголчуудын нийгмийн амьдралд тод илэрч байдаг. Зөвлөлтийн коммунизм нуран унасны дараа шинэ тутам хөгжиж буй улс төрийн соёлд үндсэрхэг үзэл чухал байр суурь эзлэх болсон. Монгол уламжлал сэргэж, түүнийг төрийн хэмжээнд тэмдэглэх болсноор Марксист-Ленинист үзлийн уналтаас үүдэлтэйгээр үүссэн хоосон орон зайг нөхөх болсон юм. Зөвлөлт засгийн үед болон Зөвлөлт засаг нуран унасны дараа ч ялгаагүй “төрсөн нутаг” гэдэг нь ариун зарчим мэт ойлгогдсоор ирсэн. Төрөөс дэмждэг соёл урлаг, ялангуяа дүрслэх урлаг, утга зохиол, яруу найраг, дуунд “сайхан эх орон”-ы тухай магтан дуулсан байдаг. “Уугуул нутаг”-т суурилсан хүмүүсийн логик нь үндэстэн-улсын хэсгүүдэд мөн хамаарах ба төрсөн нутгийн тухай ойлголт нь иргэдийн төсөөлөлд чухал үүрэг гүйцэтгэдэг байна. Бүх улс төрчид уламжлалаа сахин хүндэлж, өөрсдийнхөө уг гарал нутгийг тодотгож байдаг.

Төрсөн нутгийн ижилсэл нь социализм нуран унасны дараа 1990-ээд онд “нутгийн зөвлөл” гэх шинэ институцийг эрчимтэйгээр бүрэлдэн бий болоход хүргэсэн. Эдгээр байгууллагууд нь мөнгөн сан үүсгэх, лобби хийх зорилготойгоор байгуулагдсанаас гадна нутгийн иргэдийг тэр нутагтай холбоотой, нөлөө бүхий хүмүүстэй холбох гол үүрэг гүйцэтгэдэг байна. Эдгээр байгууллагын ихэнх нь 1990-ээд онд буюу тухайн засаг захиргааны нэгжийн 60, 70 жилийн ойн үеэр үүсч байгуулагдсан байдаг. Нутгийн зөвлөл нь төрийн бус байгууллагын статустай бөгөөд аймаг, сумдыг нийслэлд төлөөлөх болжээ. Улаанбаатар хотод ийм төлөөлөл байхгүй сумд аймгийнхаа төвд нутгийн зөвлөл байгуулах болсон байна. Эдгээр зөвлөл нь бизнес, улс төр, бусад салбарт амжилт гаргаж яваа, тухайн нутагтай холбоотой иргэдтэй харилцаа тогтоож, нутгийн зөвлөлд элсэх санал тавьдаг аж.

Бид Монголын бүлгийн ижилслийг гэр бүлээс үндэстэн хүртэлх нэг нь нөгөөдөө багтан шингэх нийгмийг бүрдүүлэгч хэсгүүд гэж үзэхэд хэцүү, маргаантай асуудал гэж ойлгож болно. Бүлгийн ижилсэл гэсэн нэр томъёо нь төрөл бүрийн хүмүүсийг хамарч уян хатан байдлаар хэрэглэгддэг бөгөөд үндэсний, бүсийн, угсаатны, шашны гэх зэрэг төсөөллийн хэлбэрүүд болон өөр өөр нөхцөл байдалд хэрэглэгддэг. Нийслэлд байгаа гадаадын иргэн, байгаль хамгаалах хөдөлгөөнд оролцогч, үндэсний эсвэл орон нутгийн чанартай ёслолд оролцогч хэн ч бай гол нь дээрх бүлгүүд нь тухайн нөхцөл байдал буюу тодорхой хэлэлцүүлэг, байр сууринаас хамааралтай байдаг. Эдгээрийг бид угсаа гарвал, холбоо хамаарал гэсэн хэлц үгийг хэрэглэн нийтлэг гарал үүслийн асуудалд анхаарахын зэрэгцээ орон нутаг дахь үндэс хамаарлаа чухалчлан тодотгох зохион байгуулалтын илрэлүүд хэмээн үзэж болох бөгөөд үүнд өрх гэрийн микро түвшний зохион байгуулалтын илрэлүүд ч мөн орно.

Үндэсний ард түмнийг цогцлоох нь

Чин болон Чин улсаас өмнөх үед Монголд хөгжиж байсан улс төрийн ижилслийн талаар эрдэмтэд өөр өөр төсөөлөлтэй байдаг боловч үндэсний ижилсэл нь тус улсад харьцангуй шинэ тутам хөгжиж байгаа гэж үзэж болно.¹ [Kaplonski 1998: 35] “үндэсний ижилслийн үүсэл 19 дүгээр зууны сүүл үеэс эхлэлтэй хэдий ч 1920-иод оноос буюу социалист дэглэм хөгжиж эхэлсэн үеэс илүү хурдацтай хөгжиж эхэлсэн. Тухайн үеийн социалист засаг Монголд “үндэстэн” гэсэн үзэл ойлголтод тулгуурлан ижилслийг бүрэлдүүлэн, сурталчлан хөгжүүлэх болсон” гэж бичсэн байдаг.

Чин гүрний үед (1691-1911) Монголыг Чингисийн удмын тайж цолтой язгууртнууд захирч байсан юм. Тухайн үед Монгол орон олон тооны хошуунд хуваагдаж байсныг тайж цолтой засаг ноён захирч байв. Энэ үед язгууртнуудын угсаа гарлаас ангидаар монгол угсаатныг тодорхойлон илэрхийлэх нь төвөгтэй байсан [Мөнх-Эрдэнэ 2006, Atwood 1994, Elverskog 2006].² Монголын жирийн ард иргэд ихэс язгууртнаас угсаа гарвал өөр байсан төдийгүй хааны удам нь язгууртны статусын үндэс нь байсан тул тэд онолын хувьд ч өөрсдийгөө ихэстэй эн зэрэгцүүлж чадахгүй юм.

Хожим нь Монголын үндсэрхэг үзэлтнүүд Монголчуудын нэгдсэн уг гарвалыг тодруулах зорилгоор түүхийн сурвалжуудыг судлах явцдаа хаад ноёдын ургийн бичээсийг олсон байна. Монголчуудын угийн бичиг нь зөвхөн хаад ноёдод хамаарах зүйл байсан юм. Атвүүдийн

¹ Түүхэн цаг үеүүдэд улс (өдгөө төр улс гэсэн утгыг илэрхийлдэг)-ын шинжийн талаар өөр өөр байр суурьтай байсан. Атвүүд (1994), Мөнх-Эрдэнэ (2006), Эльвэрског (2006) нар монгол улс гэсэн нэр томъёогоор (Мөнх-Эрдэнэ: овогтон гэсэн нэр томъёогоор ч мөн адил) тодорхойлогдох нэг төрлийн бүлгийн Монгол ижилсэл байдаг гэж үздэг (Мөнх-Эрдэнэ энэ нь овогтон гэсэн нэр томъёо)

² Монголчуудын дээд төрөл нь хожим нь энэ нэр томъёогоор илэрхийлэгдэх болсон Хорчингуудын улс төрийн гол ижилсэл байгаагүй гэж Эльвэрског үзсэн байна [2006: 16-17]

тэмдэглэснээр Чингисийн удмынхан буюу тайж зэрэгтэй хүмүүс л зөвхөн Монголын нийгмийн гишүүнд тооцогдож байжээ. Гэвч энэ байдал нь 20 дугаар зуунд өөрчлөгдөн шинэ үзэл санаа нийгэмд хөгжих болсон. Монголын үндэстэн гэсэн үзэл ойлголтод Чингисийн удмыг үлгэр болон ашигласан шинэ хэлбэрийн түгээмэл үндсэрхэг үзлийг Монголын тусгаар тогтнолын хөдөлгөөн дэлгэрүүлж эхэлсэн байна.

Социализмын үед угсаатны бүлгүүдийн талаар өнгөрсөн үеийн бурангуй байдалтай холбоотой гэж үзэхээс өөр аргагүй байдлыг нөхцөлдүүлсэн юм. Тухайн үед эрмэлзэн тэмүүлэх үнэт зүйлс нь Зөвлөлтийн цогцлоохыг хичээж байсан ахан дүүгийн социализм (братский социализм) ба ажилчин ангийн интернационализм (пролетарский интернационализм) байсан юм. Гэвч энэхүү улс төрийн ортодокс нь үндэсний популизм гэж томъёологдож болох түүхэн төсөөллийн багахан хэсэг байсан юм. Үүнийг тэмдэглэснээр миний бие элитүүд болон хот хүрээний ажилчин ангийн хоорондох холбоонд суурилсан захиргаадлын хөдөлгөөн хэмээн Германигийн тодорхойлсонтой адил ямар нэгэн улс төрийн үзэл суртлыг илэрхийлээгүй билээ. Харин дээрх нэр томъёог ашиглан үндсэрхэг болон популист үзлийн уялдаа холбоог тодорхой гаргаж ирэхийг хичээсэн юм.

Каплонскийгээс гадна би Лиа Грифэлдын санааг иш татахыг хүсч байна. Тэрээр, үндэсний ижилсэл нь иргэдийн гишүүнчлэлээс урган гарч болох бөгөөд энэ нь гишүүн бүр дээд элитүүдийнхээ шинж чанарыг хуваалцсанаар нэгдмэл адил төстэй байдлыг бий болгодог. Ингэснээр дээд давхарга нь зиндаа, эрхэм байдлаа хадгалахын зэрэгцээ тухайн үндэстний зэрэг зиндаагаараа ялгаатай хүн ам нь нийтлэг байдлаараа адил төстэй болж харагддаг байна [Greenfeld 1992: 7]. “Ард иргэдийг цогцлооно гэдэг нь улс төрийн үйл ажиллагааны шилдэг жишээ юм” гэж Лаклау [2005: 154] тэмдэглэсэн байдаг. Үндсэрхэг үзэл, популизмын аль аль нь энэ байгуулалтыг

шаарддаг боловч “тодорхойгүй ард түмэн” өөрсдийн онцлог шинжийг бүрдүүлэн тодорч гарах нь янз бүрийн хэлбэрээр илэрч болно” гэж Канован тэмдэглэсэн байдаг [Canovan 1981, 294].

Зөвлөлт маягийн үндэстэн улс байгуулах төсөл нь Оросын “народ” гэсэн ойлголттой дүйцэх Монгол нэр томъёог шаардаж байв. Анхандаа энгийн иргэд гэсэн утгатай “ард” гэсэн нэр томъёог сонгосон байдаг. Гэвч хувьсгалаас өмнөх улс төрийн хэлэлцүүлэгт нийт ард түмнийг хамааран тодорхойлсон нэр томъёо байхгүй байсан ба анги давхрагаар нь ялгасан нэр томъёог хэрэглэж байжээ. Эдгээр нь хаад ноёд буюу тайж язгууртан, шар буюу лам хувраг, хар буюу энгийн ард юм. Иймд аливаа улс төрийн мэдэгдлүүд нь нийт иргэдийг хамарсан нэгдсэн нэг нэр томъёо бус дээрх томъёоллуудыг тус бүрт нь хэрэглэдэг байжээ.

Угсаатныг байгуулах нь

Алонсогийн тэмдэглэснээр [1994: 391] үндсэрхэх үзэл хийгээд угсаатан нь ихэнхдээ нэгэн зэрэг бүрэлддэг ба “угсаатан гэдэг нь төр улс бүрэлдэх үйл явцад тухайн төрийн онцлог шинжүүдийг бүрэлдүүлэх үйл явцын нэг хэсэг үр нөлөө” гэж угсаатны антропологи тайлбарладаг байна. Угсаатны бүлгүүд бүрэлдэх түүхэн үе шатны талаарх Зөвлөлтийн онолын гол элементүүдийг монгол хэлнээ буулгасан байдаг. Орос хэлний народность (угсаатны бүлэг/үндэстэн) гэдэг үгийг монгол хэлнээ ястан гэж орчуулсан байдаг.

Олон угсаатны бүлгүүд буюу “үндэстнүүдээс” бүрэлдсэн ЗХУ-ын жишгийн дагуу Монголчууд угсаатан буюу үндэстний цөөнхийн бүлэг болох ястнаас бүрэлддэг.¹

¹ 2000 онд хийсэн хүн амын тооллогоор Монголд нийт 23 ястан бүртгэгдсэн бөгөөд дөрвөн бүлэг нь Турк, Казах, Урианхай, Узбек болон Тувачууд байна. [Дашбадрах 2006: 135]. *Народность* болон *национальность* гэсэн нэр томъёоны хөгжил, хувиралын зураглалыг Хиршийн бүтээл [1997: 267]-ээс үзнэ үү.

Энэ нь тухайн хүнийг тодорхойлох албан ёсны илэрхийлэл болсон бөгөөд БНМАУ-ын иргэний паспорт дээр аль ястан болохыг нь тэмдэглэдэг байжээ. 1989 онд явуулсан тооллогоор Монголын нийт хүн амын 79 хувь нь халх гэж бүртгүүлсэн байна. Монголд халхаас гадна нийт 25 өөр ястан байдаг гэж бүртгэгдсэнээс 1989 оны хүн амын тооллогын дүнд дараах ястнууд хамгийн их хүн амтай болох нь тогтоогджээ. Үүнд Дөрвөд (55000), Баяд (39000), Буриад (45000), Дарьганга (29000), Захчин (23000), Урианхай (21000) зэрэг ястан орсон байна.

Овог аймгийн нэгэн адил угсаатны бүлэг хэмээх үзэл ойлголт нь төрөл садангийн холбоо хэмээх ойлголтод суурилсан байдаг [Hobsbawm 1990: 63] бол “угсаатны бүлгүүд нь тодорхой, нэг ижил, нэгдмэл соёлтой, удмын сангийн хувьд нэг гаралтай байдаг гэдэг нь ташаа ойлголт” гэж Алонсо үзсэн байдаг. Үнэхээр ч ястан гэх угсаатны бүлэг нь тухайн нутгаас гаралгүй ч түүхэн цаг хугацааны явцад удирдагчид улс төрийн хувьд тодорхойлж бүрдүүлсэн нэгдлүүд юм.

Парламентын ардчилал ба авилга хээл хахууль

Шинэ үеийн улс төрийн идэвхтэн залуусын манлайлан хийсэн жагсаал, өлсгөлөнгийн дүнд Зөвлөлт маягийн Засгийн газар бууж, Үндсэн хуулийг шинэчлэхэд хүргэсэн 1990 оны “ардчилсан хувьсгалын” дараа Монгол Улс олон нам бүхий парламентын тогтолцоотой болсон. Ардчилсан хувьсгалаас өмнө төрийн эрх барьж байсан МАХН парламентын сонгуульд нийт суудлын 80 хувийг авч ялалт байгуулсан хэдий ч шинэ тутам гарч ирж буй улс төрийн намуудтай эрх мэдлээ хуваалцахаар болж, 1992 онд ардчилсан шинэ Үндсэн хуулийг батлах зэргээр улс төрийн шинэчлэлийг хийх болсон байна [Sanders 1992].

Энэ нь Монголын улс төрийн тогтолцоог парламентын болон ерөнхийлөгчийн засаглалуудын зааг дээр аваачсан

юм [Мөнх-Эрдэнэ 2010]. МАХН 1992 оны сонгуульд ялалт байгуулсан бол Ардчилсан холбоо эвсэл 1996 онд ялалт байгуулсан билээ. МАХН улс төрийн тэргүүлэх хүч хэвээр байсан ба 2000 оны сонгуульд үнэмлэхүй ялалт байгуулсан юм. Гэвч сөрөг хүчний намууд 2004 оны сонгуульд амжилттай оролцсоноор парламентад суудал тэнцэж, эвслийн засгийн газар байгуулагдсан. 2008 оны сонгуулиар МАХН дахин ялалт байгуулсан ч анх удаагаа Монголд сонгуулийн дүнг эсэргүүцсэн ширүүн жагсаал цуглаан болсноор иргэд амь насаа алдсан бөгөөд онц байдал зарлаж байсан.

Монголын парламентын тогтолцоо анхнаасаа “нөхөрлөлийн” шинжтэй [Lijphart 1999] байсан ба энэ байдал нь үе үе улс төр дотооддоо ширүүхэн тэмцэлддэг хэдий ч тодорхой хэмжээнд эрх мэдэл хуваалцах байдлаар илэрч байдаг. Ялагчид улс төрийн ангиудын хэт хуваагдлаас сэргийлэхийг хичээж өрсөлдөгчиддөө аль болох цөөн албан тушаал авах боломжийг олгодог. Энэ нь шинэ тогтолцоо бүрэлдсэн анхны үед аль аль хүчнийхний хувьд улс төрийн өрсөлдөөн нь амь өрссөн тэмцэл байгаагүй ба маргаан нь нухацтай байх тусам тогтолцоо бүхэлдээ ширүүн шалгууртай тулгаралгүйгээр тогтворжиж байсан.

Мөн эрх баригч нам солигдоход нийгмийн салбарын дээд албан тушаалд томоохон өөрчлөлт орсоор ирсэн ч тогтвортой байдлаа тодорхой хэмжээнд хадгалсаар ирсэн. Үүний адил телевизийн суваг, сонин хэвлэлээр улс төрийн янз бүрийн байр суурь илэрхийлэгдэж намын бодлогын хүрээг огтлолцуулж байдаг. Хуучин социалист орнуудтай адил авилгал¹ эрчимтэйгээр өссөн байна. Монголчууд, тэр дундаа

¹ Авилгал гэдэг үг нь авах гэсэн үгнээс гаралтай ба хууль бус орлого олох, хүчээр мөнгө авах, шунах гэсэн үгтэй авилгалах гэдэг үгтэй нягт холбоотой. 1990-ээд оны сүүлч гэхэд Монголчууд аливаа ажлыг гүйцэлдүүлэхэд ямар нэгэн “гар цайлгах” зүйл өгөх хэрэгтэй болсон байсан. 1500 монголчуудын дунд Засгийн газраас явуулсан судалгаагаар социализмын дараа авилгал нэмэгдсэн гэж 70 хувь нь үзсэн бол ердөө 7 хувь нь социализмын үед ч авилгал өргөн дэлгэрсэн байсан гэсэн байна [Снийт

шинээр гарч ирж байгаа элитүүд, чинээлэг бизнесменүүд болон улс төрчид хээл хахуулийг Монголын өдөр тутмын амьдралын нэгэн хэсэг мэтээр бодох болсон. Энэ нь “зах зээлийн үе” гэсэн социализмын дараах нийтлэг төсөөлөлтэй холбоотой юм. Өдөр тутмын авилгалын асуудлыг нийгэмд байсаар ирсэн “танил тал” буюу харилцан туслах, бэлэг өгөх гэсэн ойлголтоос ялгаж үзэх хэрэгтэй юм. Энэ нь социализмын үед гэр бүл, найз нөхдөөрөө туслуулж, тэдэнд туслах, эд зүйл авах арга зам нь байсан бөгөөд энэ нь авилгад тооцогддоггүй байсан.

Зах зээлийн үед бэлэн мөнгөний тооцоо чухал болж, авилгал хээл хахууль борооны дараах мөөг шиг олширсон байна. Гэхдээ танил талуудын хооронд нийгмийн харилцаан дахь харилцан туслалцаа нь баян, ядуугийн хоорондох авилга гэж үзэгдэх бус арай өөр утгаар ойлгогддог [Sneath 2006: 100-101]. Олон нийтийн энэхүү ойлголт нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр тасралтгүй гарах авилгалын хэрэг болон цөөн хүмүүсийн хэтэвчийг зузаалж, үлдсэн хэсгийг хоосон хоцроосон өмч хувьчлалын гашуун туршлагыг тусгаж байдаг. Социализм нуран унасны дараа авилгал нь өргөн утгаараа олон нийтийн дунд ёс суртахууны ялзралын талаарх ойлголтыг түгээх болсон юм. Мөн элитүүд буюу нийгмийн дээд давхрагынхан олон нийтийн хөрөнгө мөнгийг идэж байна гэсэн сэрдлэг нийтийн дунд байдаг.

Эрх мэдлийг хуваарилах болон зөвшилцөл байгуулах нь хувь сонирхол бүхий элитүүд улс төр, эдийн засгийн эрх мэдлийг хамтад нь монопольчилж байна гэсэн зовнилыг олон нийтийн дунд төрүүлж болох юм гэдгийг 2008 онд болсон тэмцэл хөдөлгөөн харуулсан. Түүнчлэн олонх нь гадаадын хөрөнгө оруулалт, гадаад эзэдтэй уул уурхайн компаниудын үйл ажиллагааны идэвхижилд анхаарал хандуулах нь нэмэгдсэн бөгөөд эдийн засгийн үйлдвэрлэлүүд өссөн бол бусад үйлдвэрлэл хохирол амссан байна.

Гадаадын компаниуд Монголын улс төрчдөд авилга өгч, улс орны ашигт малтмалын баялгийг хаман авч байна гэсэн айдас иргэдийн дунд бий болжээ. Нэг талаас гадаад, дотоодын томоохон бизнесүүдийн хэт тансаг байр сууц, нөгөө талаас эмх замбараагүй тоо томшгүй хувийн ойлголт ба үйл ажиллагаатай улс төрийнхөн холилдсон явдал нь олон нийтийн дунд эргэлзээ, сэтгэл дундуур байдлыг бий болгосон байна. Иргэдийн дунд улс төрийнхөнд үл итгэх байдал их байгаа ч Өрнөдийнхний жишгээр иргэдийн сонгуулийн оролцоо харьцангуй сайн байсаар байна. 2004 оны парламентын сонгууль дахь иргэдийн оролцоо 60 хувьтай [Туяа 2005: 68] байсан бол иргэд 2008 оны парламентын сонгуульд 76, 2009 оны Ерөнхийлөгчийн сонгуульд 74 хувьтай тус тус оролцсон байна.

Сонгуулийн тойргуудад хуваарилагдсан парламентын суудлын тоо хөдөөгийн тойргуудад¹ илүү боломжийг олгох хандлагатай байдаг. Улс төрчид тус тусын тойрогтоо хөрөнгө татаж зарцуулахыг оролдохын зэрэгцээ тухайн нутагтай холбогдох өөрсдийн холбоогоо онцгойлох замаар сонгогдсон тойрогтоо үнэнч байхыг хичээж байдаг. Энэхүү хэт их хөрөнгө мөнгийг тойрогтоо цацан, сонгогчдыг өөртөө татах гэсэн улс төрийн хандлага нь Монголын хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр нэлээд шүүмжлэгддэг.

Улс төрийн хувьд дотоод дахь хамгийн чухал бүлгийн ижилсэл нь угсаатан биш харин нутаг юм. Нутаг дэвсгэр нь хэд хэдэн шатлал бүхий засаг захиргааны нэрлэсэн нэгжүүдэд хуваагддаг тул ихэнх тохиолдолд нутаг гэдэг нь нэр томъёоны хувьд засаг захиргааны нэгжийн хүрээнд ойлгогддог.

Социализмын дараах угсаатны зохион байгуулалт

Угсаатны бүлэг-ястан нь хэдийгээр социалист нийгмийн үед бүрэлдэж тодорхойлогдсон боловч Зөвлөлтийн

¹ Ихэнх аймгууд арваас хорин мянган сонгогчид тутамд парламентын нэг суудал хувирилагдсан байдаг бол хотод нэг суудалд хорин мянган сонгогчид ноогддог байна. МАХН хөдөөгийн тойргуудад илүү дэмжлэг авдаг нь тус нам бусад намуудаас илүү орон нутагт салбар хороодоо зөв зохион байгуулсантай холбоотой.

нөлөөллийн эриний сүүл үед ч гэсэн бүлгийн ижилслийн ач холбогдолыг бууруулж байсан. Үндэс гарвалаа дахин нээн тогтоох, уламжлалт соёлоо сэргээх үйл явц Зөвлөлтийн модернизмын нөлөөн дор дарагдаад байсан ч 1990-ээд оноос тэрхүү үйл явцын дахин сэргэлтийн нэг хэсэг болж угсаатны бүлгүүд дахин тодорч эхэлсэн юм.

Социализмын дараах үеийн эдийн засаг, нийгмийн хямралын үед харилцан туслалцах сүлжээг тодорхойлохын тулд бүлгийн ижилслийн бүхий л төрлийг ашигласан байдаг. Ястны бүлэгт хамрагдах хүмүүсийн зарим хэсэг нь тодорхой хэмжээнд харилцан холбоотой, нэгдсэн үндэс гарвалтай байдаг. Гэвч ихэнх монголчууд өөрсдийн угсаатны гарвал хамаарлын асуудлаас илүү нутгийн ижилсэлд түлхүү анхаарал хандуулдаг байна.

Өнөөдрийг хүртэл үндэстнийг хамарсан угсаатны сөрөг зохион байгуулалт гараагүй байна. МАХН болон сөрөг хүчний намууд казах гишүүдтэй бөгөөд парламентад суугаа тэдгээр гишүүд нь казах иргэд олноороо төвлөрөн суудаг Баян-Өлгий аймгаас сонгогдсон байдаг боловч нийлж улс төрийн эвсэл байгуулаагүй байна. Монголд казах соёлын хэд хэдэн байгууллагууд байдаг ба Казахстан болон Исламын шашинт бусад улс оронтой холбоотой ажилладаг боловч улс төрийн нам, эвсэл болтлоо өргөжсөн нь үгүй. Гэвч угсаатны соёлын үйл ажиллагаа нь нам, улс төрийн үйл ажиллагаатай харьцуулахад хүч гарзадсан зүйл байдаг.

Дүгнэлт

Парламентын улс төрийн эрин үед уламжлалаа дахин сэргээх, бүлгийн ижилсэл болон харилцан хамаарлын үзэл ойлголтыг төлөвшүүлэн бэхжүүлэхэд ёслол болон нийтийн зан үйл чухал үүрэг гүйцэтгэсээр байна. Дээрхээс үзэхэд бүлгийн ижилсэл гэсэн нэр томъёо нь энд ерөнхий агуулгаар хэрэглэгдэж байгаа бөгөөд төрлийн холбоо, угсаатан-үндэстний түүх, нутаг орны хамаарал зэрэг асуудлаар тодорхой хэмжээнд нийтлэг, төстэй гэдгээ мэдэрч байгаа хүмүүсийн нэгдлийг тодорхойлж байна.

Хэдийгээр үндэсний ард иргэд гэсэн ойлголт нь олон нийтийн соёлд гүнзгий суусан байдаг ч бүлгийн ижилслийн бусад хэлбэрийг идэвхжүүлэх, улс төрчид болон бусад хүмүүсийн зүгээс харилцан туйлбартай, нэгдмэл байх тухай тунхаглан илэрхийлэх нь ихэнхдээ амлалт, төлөвлөгөө төдий үлддэг. Тэд үргэлж амжилттай байж чаддаггүй байна. Зарим хүмүүс угсаатны түүх, ижилсэлд илүү анхаарал хандуулдаг боловч ихэнх нь үүнийг чухалчилж үздэггүй байна. Гэр бүл, найз нөхдийн хүрээнээс гадна дийлэнх хүмүүсийн голчлон ач холбогдол өгдөг ижилсэл бол сум, аймаг зэрэг засаг захиргааны нэгжүүд буюу харъяалагдах, эсвэл ямар нэгэн байдлаар холбогдох нутаг юм.

Бүхэлд нь харахад, Монголчуудын хувьд бүлгийн ижилсэл гэдгийг гэр бүлээс үндэстэн хүртэлх нэг нь нөгөөдөө багтан шингэх нийгмийг бүрдүүлэгч хэсгүүд гэж үзэхэд хэцүү, маргаантай асуудал гэж ойлгож болно. Бүлгийн ижилсэл гэсэн нэр томъёо нь төрөл бүрийн хүмүүсийг хамарч уян хатан байдлаар хэрэглэгддэг бөгөөд үндэсний, бүсийн, угсаатны, шашны гэх зэрэг төсөөллийн хэлбэрүүд болон өөр өөр нөхцөл байдалд хэрэглэгддэг. Нийслэлд байгаа гадаадын иргэн, байгаль хамгаалах хөдөлгөөнд оролцогч, үндэсний эсвэл орон нутгийн чанартай ёслолд оролцогч хэн ч бай гол нь дээрх бүлгүүд нь тухайн нөхцөл байдал буюу тодорхой хэлэлцүүлэг, байр сууринаас хамааралтай байдаг.

Эдгээрийг бид угсаа гарвал, холбоо хамаарал гэсэн хэлц үгийг хэрэглэн нийтлэг гарал үүслийн асуудалд

анхаарахын зэрэгцээ орон нутаг дахь үндэс хамаарлаа чухалчлан тодотгох зохион байгуулалтын илрэлүүд хэмээн үзэж болох бөгөөд үүнд өрх гэрийн микро түвшний зохион байгуулалтын илрэлүүд ч мөн орно.

Ашигласан хэрэглэхүүн:

1. Alonso, A. M., 1994. The Politics of Space, Time and Substance: State Formation, Nationalism, and Ethnicity. *Annual Review of Anthropology*, 23, 379-405.
2. Atwood, C., 1994. National Questions and National Answers in the Chinese Revolution; Or, How Do You Say Minzu in Mongolian? Indiana East Asian Working Paper Series on Language and Politics in Modern China (Winter 1994), Available from: http://www.indiana.edu/~easc/resources/working_paper/noframe_5b.htm
3. Atwood, Christopher (2004) *Encyclopedia of Mongolia and the Mongol Empire*, New York: Facts on File.
4. Boldbaatar, J., and Sneath, D. 2006. Ordering Subjects: Mongolian Civil and Military Administration, in Sneath D., ed., *Imperial Statecraft: Political forms and techniques of governance in Inner Asia 6th – 20th centuries*. Bellingham: Western Washington University, 293-314.
5. Bourdieu, P. 1977. *Outline of a Theory of Practice*. Cambridge: Cambridge University Press.
6. Brubaker, R., 1996. *Nationalism reframed: nationhood and the national question in the New Europe*. Cambridge: Cambridge University Press.
7. Bulag, U., 1998. *Nationalism and hybridity in Mongolia*. Oxford: Clarendon Press.
8. Canovan, M., 1981. *Populism*. London: Junction books.
9. Dashbadrakh, D. 2006. 'Demography' In: Canzhid, A., ed., *History and Culture of the Mongols*. Ulaanbaatar: IISNC, 132-135.
10. Elverskog, J., 2006. *Our Great Qing: The Mongols, Buddhism, and the State in Late Imperial China*. Honolulu: University of Hawaii Press.

11. Gellner, E., 1983, *Nations and Nationalism*. Oxford: Blackwell.
12. Germani, G., 1978. *Authoritarianism, fascism, and national populism*. New Brunswick NJ: Transaction Press.
13. Greenfeld, L., 1992. *Nationalism: Five Roads to Modernity*. Cambridge MA: Harvard University Press.
14. Hirsch, F., 1997. The Soviet Union as a Work-in-Progress: Ethnographers and the Category of *Nationality* in the 1926, 1937, and 1939 Censuses, *Slavic Review* 56 (2): 251-278.
15. Hobsbawm, E., 1990. *Nations and Nationalism Since 1780*. Cambridge: Cambridge University Press.
16. Humphrey, C., and Sneath D., 1999. *The End of Nomadism? Society, State and the Environment in Inner Asia*. Durham: Duke University Press.
17. Kaplonski, C., 1993. Collective memory and Chingunjav's rebellion, *History and Anthropology* 6(2-3), 235-259.
18. Kaplonski, C., 1998. Creating national identity in socialist Mongolia, *Central Asian Survey* 17(1), 35-49.
19. Kaplonski, C., 2004. *Truth, History and Politics in Mongolia: The memory of heroes*. London: RoutledgeCurzon,.
20. Laclau, E., 2005. *On populist reason*. London: Verso.
21. Lijphart, A., 1999. *Patterns of Democracy: Government Forms and Performance in Thirty Six Countries*. New Haven: Yale University Press.
22. Linz, J. and Stepan, A., 1996. *Problems of democratic transition and consolidation: southern Europe, South America, and Post-Communist Europe*. Baltimore: Johns Hopkins University Press.
23. MacRae, D., 1969. Populism as an Ideology In Ionescu, G., and Gellner E., (eds) *Populism: its meanings and national characteristics*. London, Weidenfeld & Nicolson, 153-165.
24. Malkki, L., 1992. National Geographic: The Rooting of Peoples and the Territorialization of National Identity among Scholars and Refugees. *Cultural Anthropology*, 7 (1), 24-44.
25. Munkh-Erdene, L., 2006. The Mongolian nationality lexicon: From the Chinggisid lineage to Mongolian nationality (From the seventeenth to the early twentieth century). *Inner Asia*, 8 (1), 51-98.

26. Munkh-Erdene, L., 2010. The transformation of Mongolia's political system: From semi-parliamentary to parliamentary? *Asian Survey* 50 (2), 331-334.
27. Quan, L., and Rafael, R., 2003. Economic Globalization and Democracy: An Empirical Analysis. *British Journal of Political Science*, 33 (1), pp 29-54
28. Rose, R., 2001. How People View Democracy: A Diverging Europe. *Journal of Democracy*, 12 (1) 93-106
29. Sanders, A., 1992. Mongolia's New Constitution: Blueprint for Democracy, *Asian Survey*, 32 (6) 506-520.
30. Sneath, D., 2006. Transacting and Enacting: Corruption, obligation and the use of monies in Mongolia. *Ethnos*, 71 (1), 89-112.
31. Sneath, D., 2007. *The Headless State: Aristocratic Orders, Kinship Society, and Misrepresentations of Nomadic Inner Asia*. New York: Columbia University Press.
32. Stalin, J., 1970. Marxism and the National Question: The Nation [and] The National Movement [1913]. *In Selections from V. I. Lenin, and J. V. Stalin on National Colonial Question*. Calcutta: Calcutta Book House.
33. Tuya, N., 2005. Mongolia in 2004: Testing Politics and Economics. *Asian Survey*, 45 (1) 67-70.
34. Vreeland, H. H., 1962, *Mongol Community and Kinship Structure*. New Haven: Human Relations Area Files.
35. Verdery, K., 1996. *What was socialism, and what comes next?* Princeton NJ: Princeton University Press.
36. Worsley, P., 1969. The Concept of Populism *In* Ionescu, G., and Gellner, E., eds., *Populism: its meanings and national characteristics*. London, Weidenfeld & Nicolson, 212-250.
37. Yang, H. and Bulag U., 2003. *Janggiy-a Qutughtu: A Mongolian Missionary for Chinese National Identification*, *Mongolian Culture Studies* 5, Cologne: International Society for the Study of the Culture and Economy of the Ordos Mongols.
38. Д.Гонгор., 1978. *Халх товчоон (I,II)*, Улаанбаатар: БНМАУ-ын ШУА-ийн Түүхийн хүрээлэн
39. Ж.Болдбаатар., Д.Лүндээжанцан., 1997. *Монгол улсын төр, эрхзүйн түүхэн уламжлал*, Улаанбаатар: Адмон хэвлэлийн газар.

40. М.Хурметхан., 2007. *Монгол улсын казахууд: Антропологи, уг гарвал, хүн ам зүй*, Улаанбаатар: Монголын ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн.
41. Намжилмаа, 1988. Ред., *Хорин наймт тайлбар толь*, Хөх хот: Өвөр монголын ардын хэвлэлийн газар.
42. Ринчин., 2001. *Монгол Судлалын өгүүллийн түүвэр*, Хөх хот: Өвөр монголын ардын хэвлэлийн газар.
43. Ц.Гайтав., 1978. *Сайхан эх орон*, Улаабаатар: Улсын хэвлэлийн газар.